



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 21

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэтэй, 90,000 (Ерэн мянга) төгрөгийн үлдэх өртөгтэй мэдээлэл хадгалах зөврийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан), Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
21 дүгээр тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчийн газраас Эрүүл мэндийн газарт  
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт



№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Мэдээлэл хадгалах зөөврийн тоног төхөөрөмж	2016.09	ш	1	300,000	210,000	90,000	Эрүүл мэндийн газар
<b>Нийт дүн</b>				<b>1</b>	<b>300,000 /гурван зуун мянган/ төгрөг</b>	<b>210,000 /хоёр зуун арван мянга/ төгрөг</b>	<b>90,000 / Ерэн мянга/ төгрөг</b>	